

Соёмбо нь монгол үндэстний оюун сэтгэхүйн феномэн болох нь *Соёмбо үсэг зохиогдсны 340 жилийн ойд зориулав.*

Оросын Болор-Эрдэнэ, магистр

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс, bolorerdene_o@mas.ac.mn

<https://orcid.org/0009-0002-6291-8055>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

*Соёмбо, Монгол соёл
иргэнишл, Үндэстний
оюун сэтгэхүй,
Үндэстний адислахуй,
Бэлгэ тэмдэг, Түүхийн
ажил хэрэг*

Хураангуй: Эртний “номт гурван улсын” соёл иргэншлээс улбаатай “соёмбо” нь монгол үндэстний угсаа түүх, хэл соёл, шашин шүтлэгтэй нягт холбогдож ирсэн учраас Монголын улсын бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг, үндэстний адислахуйн онтологи утгын илэрхийлэл болж байдаг. Уг өгүүллийн зохиогч соёмбыг монгол үндэстний оюун сэтгэхүйн “нууцыг” тайлах түлхүүр гэж үзэх санааг дэвшүүлсэн болно. Ингэхдээ энэхүү гайхамшигт феномэний олон талын учир холбогдлыг (семантик талбарыг) дурьдах замаар соёмбо тэмдэгт явагдсан хувьсгал өөрчлөлт нь монгол оюун сэтгэхүйд явагдсан түүхийн ажил хэргийг илтгэн буйг харуулахыг зорьжээ.

«Soyombo» as a phenomenon of the Mongolian national spirit

Bolor-Erdene Oros, MA

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, bolorerdene_o@mas.ac.mn

<https://orcid.org/0009-0002-6291-8055>

Keywords

*Soyombo,
Mongol civilization,
nation's spirit,
nation identity,
symbol, historical
dynamics*

Abstract: "Soyombo" is a symbol that traces back to the ancient civilization of the "three countries of dharma" (India, Tibet, Mongolia) and is closely related to the history, language, culture, and religious views of the Mongolian people. Therefore, the author of the article suggests that Soyombo can serve as a key to uncovering the "secrets" of the Mongolian nation's spirit. To aims to this goal, the author demonstrate the complex aspects of this remarkable phenomenon, which reflects the true meaning of Mongolian identity, showing that the evolution and transformation of the Soyombo symbol itself point to the historical dynamics unfolding in Mongolian intellectual history.

© The Author(s), 2025



ᠰᠣᠶ᠋ᠠᠮᠪᠠᠨ (самгарьд хэлний “swayambhu”, स्वयंभू – монгол бичигт “soyombu” ᠰᠣᠶ᠋ᠠᠮᠪᠠᠨ - «өөрөө ургасан гэгээн») бол эртний энэтхэгээс эхтэй номт гурван улсын соёл иргэншлээс улбаатай бэлгэт тэмдэг бөгөөд монгол үндэстний төрт ёсны түүх, хэл соёл, шашин сэтгэлгээтэй нягт холбоотой байж ирсэн учраас монгол үндэстний оюун сэтгэхүйн «нууц»-ыг тайлах түлхүүр байж болох юм.

Монгол хэлний их тайлбар тольд “Соёмбо” хэмээхийг: “Өндөр гэгээн Занабазарын 1686 онд энэтхэгийн ланз үсэгт тулгуурлан зохиосон цагаан толгойт бичиг; 2. Сав ертөнцийн оршлыг бэлгэдсэн шороо, ус, гал, хий, огторгуйг дүрслэн, бас шим ертөнц буюу хүний биеийн бүтцийг тусгасан үсэг 3. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл болгож төрийн далбаан дээр урласан бэлгэ тэмдэг” (mongoltoli.mn/dictionary/detail/77754) гэж тайлжээ.

Монголчуудын оюуны ертөнцийн манлайд “соёмбо титэм” болж дээдлэгдэх болсон түүхийн шижим нь урт бөгөөд “бүтэн цогц”: гүн ухааны ухагдахуун, төрийн эрхэм сүлд, адистид нэгэн бичиг болж бүтээгдснийг мөшгин үзвээс наана гурван зуун, цаана хоёр мянганыг хол түүхтэй монгол оюун сэтгэхүйн гайхамшигт феномэн болж байгаа билээ.

Монгол үндэстний оюун санаанд олон талын учир холбогдолтой нэн гүнзгий судлагдахуун учраас үүнийг дагалдан “Соёмбо судлал” эрт, эдүгээгийн монгол мэргэдийн дунд хөгжжээ. Соёмбын утга учрыг тайлах-сурвалжлах эрдмийн ажил үндсэндээ соёмбо үсэг зохиогдсон тэр үеэс монгол мэргэдийн төвд монголоор хийсэн тайлбаруудаас эхэлдэг ажээ. Тухайлбал, Заяа бандида Лувсанпэрэнлэй, их эрдэмт Шрибазар тэргүүтэй төвд хэлээр тайлбар бүтээл туурвисан эрдэмтэд олон байдаг.

Харин орчин цагийн шинжлэх ухааны үүднээс соёмбыг тайлбарлах ажлыг 1940 оноос Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен болон монголч судлаач Кара Дорж, Х.Нямбуу нарын эрдэмтэд эхлүүлсэн байна. 1990-ээд оноос энэ чиглэлийн судалгаа идэвхижсэн бөгөөд Л.Хүрэлбаатар, Б.Болдсайхан, Б.Даш-Ёндон, Т.Булган, Ц.Шагдарсүрэн, Г.Чулуунбаатар, Ц.Мөнх-Эрдэнэ нарын эрдэмтэд олон янзын аспектаар судалцгааж, өөрсдийн санал дүгнэлтүүдийг дэвшүүлжээ. Чингэхдээ соёмбын судалгаа бичиг үсэг, түүний гүн ухааны агуулга, бэлгэдэл зүй, нийгэм улс төрийн агуулга, хэл шинжлэлийн гэсэн чиглэлтэй байдаг байна.

Энэхүү эрдмийн өгүүлэл нь соёмбын онц чухал, гүн далд бэлгэдэл дээр тайлбар сэлт нэмэх оролдлого огт биш. Бид дээрх эрдэмтэн мэргэдийн судалгаа, сурвалж хэрэглэгдэхүүнд тулгуурлан соёмбо хэмээх гайхамшигт феномэний тухайд монгол үндэстний оюун сэтгэхүй хийсэн ажлыг ухамсарлан ойлгох гэж оролдох учраас энэ нь асуудал дэвшүүлсэн, илүүтэй таамаглал шинжтэй байх болно. Арга зүйн хувьд “түүхэн уламжлалын туршлага нь ерөнхийдөө түүний судлагдахуунаас давж гардаг. Тухайн судлагдахуун түүхэн шүүмжлэлийн харилцаанд үнэн юмуу худал байхаас гадна хамтран үйлдвэл зохих үнэнийг ямагт тунхаглан байх авай” (Гадамер Г. 1988:40) хэмээх херменевитик зарчим баримтлахыг хичээв.

Чингэхдээ соёмбыг монгол үндэстний “оюун сэтгэхүй – бэлгэ тэмдэг – адилсан танигдахуй” гэсэн харилцаанд авч үзсэн болно. Ер оюун сэтгэхүй хэмээгч нь дээд эрэмбийн бодит байдал учраас гагцхүү бэлгэ тэмдэгт тусан илэрхийлэгдэх боломжтой. Үндэстний оюун сэтгэхүй нь нэг талаасаа тухайн үндэстний адилсан танигдахуйн (national identity) онтологи үндэс болдог гэвэл, нөгөө талаасаа

үндэстний түүхэн уламжлал, ой санамж, соёлын өв сантай салшгүй холбоотой байж таарна.

Эдүгээ адилсахуйн төлөөх тэмцэл дэлхийн бодлогын гол хүчин зүйл болж хувирсанаас үүдэн улс орон бүр татагдан орж байгаа нөхцөлд монгол ахуйн өөрчлөлтийн талаарх цогц (философийн) ойлголт нь монголчуудын өөрийгөө танихуйн асуудлыг үндэслэхэд, түүнчлэн дэлхий дахинд өрнөж буй өөрчлөлттэй харьцуулан байр сууриа тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Эл “соёмбо” хэмээх гүн их утгат бэлгэдэл эдүгээ монгол төрийн бэлгэ тэмдэг болсон нь санамсаргүй хэрэг биш, монголчуудын соёл сэтгэхүйн үндэс лугаа эртний түүхтэй учраас түүний улбааг соёл иргэншлийн дэвсгэр дээрээс мөшгин үзэх нь арга зүйн ач холбогдолтой гэж үзлээ.

Дэлхийн нэрт эрдэмтэд монгол соёл иргэншлийн тухай огт дурдаагүй эсвэл аль нэгэн соёл иргэншлийн хэсэг гэж үзэх явдал ажиглагддаг. Ийм үнэлгээ тэдний үзэл санаа болон баримтлах шалгуураас бас ихээхэн хамааралтайг бодолцох хэрэгтэй биз ээ.

Бид соёл иргэншлийн тухай асуудалд хандахдаа түүнийг нийгмийн хөгжлийн тодорхой үе шаттай холбож үздэг шугаман-формацит (зэрлэг үе, бүдүүлэг үе, иргэншсэн үе гэх мэтээр) загварыг биш, харин өвөрмөц соёл бүхий зарим нийгэм соёл иргэншил болтлоо тэлж чаддаг бөгөөд соёл-иргэншил бүр давтагдашгүй байдаг тухай үзэл санааг баримталсан нь бидний ажлын зорилгод (нийгмийн оюун санааны үндэс, үнэт зүйлсийг авч үзэхэд) илүү нийцэж байгаатай холбоотой юм.

Олон янз соёлын бодит байдлыг хүлээн зөвшөөрдөг сэтгэгчид, бүх соёл гагцхүү Европын соёлыг тойрон эргэлдэх мэт түүхийн “потлемейн тогтолцоо”-нд шүүмжлэлтэй ханддаж ирсэн билээ. Тухайлбал О.Шпенглер,

«маш олон баримтыг үл ойшоосон нөхцөлд л хүчин төгөлдөр байж чадах даян дэлхийн түүхийн шугаман хэлбэрт эл уйтгартай дүр зургийн оронд олон янзын хүчирхэг соёлуудын оролцон тоглосон жүжгийг дэлхийн түүхээс би харж байна. Тэдгээр нь оршин байх бүхий л хугацаандаа салшгүй холбоотой байж ирсэн эх нутгийн хэвлийгээс олдсон адистэд хүчээр цэцэглэн хөгжихдөө, бүгдээрээ хүн төрөлхтний түүх хэмээх материал дээр өөрсдийн хэлбэрийг тамгалан үлдээсэн бөгөөд бүгдэд нь **өөрийн санаа** (*Орч.тодотгов*), өөрийн сонирхол, өөрийн амьдрал, хүсэл зориг, мэдрэхүй бас өөрийн мөхөл бий» (Шпенглер О. 2023: 45) гэж үздэг.

Чингэвэл, биеэ даасан монгол соёл иргэншлийн тухай ч яригдах бөгөөд тэр нь нэг үндэстэн улсын хүрээгээр хязгаарлагдахгүй олон улс дах монгол угсаатнуудыг хамарсан байх нь түүхийн явцаас харагдах юм. Энэ нь юун түрүүнд орчиндоо дассан зохицсон соёлын гүнээс бий болоод хүмүүсийн амьдралын чиг баримжаа болж чадсан ертөнцийг үзэх үзэл байж, тэр нь тухайн нийгмийн бүх хүрэнээ (төрт ёс, урлаг соёл, үйлдвэр технологи, хэв ёс хийгээд цээр гэх мэт) нэвчин орсон байгаа тийм системийн тухай яриа мөн. “Монголчууд олон мянган жилээр оршин аж төрж ирсэн байгаль газар зүйн нөхцөл, нүүдлийн амьдрал, дорно өрнийн олон ард түмэнтэй харилцаатай байсан зэрэг нь лавтай хоёр мянга гаруй жилийн өмнө эх үндэс нь тавигдсан соёл иргэншил үүсэн бүрэлдэх, түүний дотор ертөнцийг үзэх үзэл төлөвшин тогтох үндэс нь болсон юм. Хэсэг бусгаараа зөвхөн овгийн зохион байгуулалтаараа нүүдэллэн амьдарч ирсэн бус өөрийн гэсэн төр улсаа байгуулснаас хойш өдий олон жилийг ардаа хийсэн нь бие даасан соёл иргэншил үүсэн төлөвших хангалттай хугацаа мөн...” (Цанжид А. 2005: 48) гэж эрдэмтэд үзэж байна.

Монгол соёл иргэншил үүсэн төлөвшсөн цаг хугацааны хувьд гэвэл монголын нэгдсэн төр улс бий болж монгол үндэстэн бүрэлдсэн XIII зууныг заадаг нь энэ үед монгол соёлын хөрсөнд мянган жил дуншиж байсан “өөрийн санаа” хөгжил цэцэглэлтийнхээ оргилд хүрсэнтэй холбоотой. “XIII зууны эхэнд монгол нүүдэлчдийн оюун санааны өөрийн ухамсар, Чингис хааны сэтгэлгээний арга нэгэнт болж чадсан байсан” (Ган-Өлзий Ч. 2022:) гэж үзэж байгаа бөгөөд монгол хэл соёлын хүмүүнлэг ахуй өөрийн дүр төрхийг энэ үед олсон учраас монгол соёл иргэншлийн «тэнхлэг үе» ч гэж нэрлэж болох юм.

Чухамдаа “Соёмбо” нь энэ соёл иргэншлийн оюун санаатай нягт холбоотой болохыг бид батлах гэж оролдох болно. Энэ соёл иргэншлийн төв болсон монгол үндэстний оюун сэтгэхүйн агуулгыг соёмбо тэмдэгт тусгадаг гэж үзэх саналтай байгаа юм. Энэ тухай тодруулахын урьд үндэстний оюун сэтгэхүйн тухай товч өгүүлье.

Ер ард түмнүүдийн онцлог зан чанарын тухай эрт цагаас ажиглаж мэдсэн бөгөөд угсаатны сэтгэлзүйн судлагдахуун болж боловсорсон буй. Монголчууд “усыг нь уувал ёсыг нь дага”, “ёс ёмбогор, төр төмбөгөр” гэх мэтээр хэлэлцдэг. Өрнө дахинаа сэтгэгчид ард түмнүүдийн адилгүй шинж чанарыг харьцуулан үзэж тэдний социаль амьдралд хэрхэн нөлөөлж байгаад анхаарч ирсэн буй. Тухайлбал Гегель үндэстний оюун санаа үүсэх гурван үндсийг нь: антропологи суурилсан төрлөх шинж чанар, амьдрах орчин ба түүхэн нөхцөл, ёс уламжлал зэргээр тодорхойлжээ (Гегель Г. 2024: 67). XIX зуунаас угсаатны сэтгэлзүй бий болсоноор В.Вундат зэрэг эрдэмтэд “ард түмний сэтгэл” гэдэг ойлголтод үндэслэн энэ шинжлэх ухааны зорилго, зорилтыг тодорхойлох гэж оролдож байжээ.

Угсаатны сэтгэлзүйд “хувь хүний сэтгэл”-ийн үйл явцуудыг илүү

өргөтгөсөн утгаар “ард түмний сэтгэл”-ийн тухай ярьдаг. Ийнхүү үзвэл, ямар ч үндэстэн нь хувь хүний нэгэн адил ухаан бодол, зан суртахуун, мэдрэмжтэй байх юм. Хэлний субьектив үйл ажиллагааны үр дүнд объектив хэл бүрэлдсэнтэй адил, хамтран аж төрж ирсэн хүмүүсийн оюуны субьектив үйл ажиллагаа он удаан жилийн явцад тэдний оюуны объектив агуулгыг бий болгож, тэр нь буцаад хүмүүсийн үйл ажиллагаанд нөлөөлөх болсон байж болно. Хувь хүмүүсийн нийлбэр төдий нь үндэстнийг бий болгохгүй, харин тэдний нэгтгэдэг “ард түмний сэтгэл” гэж байх ёстой ажээ.

Бие, сэтгэл хоёрын эсрэг тэсрэг байдлыг онцлох замаар оюун санааны тухай ярьж байвал зөвхөн хүнд л хамаатай хэрэг болох бөгөөд энэ тохиолдолд үндэстний оюун сэтгэхүй гэгчийг зүйрлэсэн утгаар л ярьж болно. Тийм психологи тодорхойлолтыг энд бид баримтлахгүй.

Философид “оюун санаа” гэдгийг бодитой юмс үзэгдэлээс ангидах төгс хийсвэр зүйлийн утгаар хэрэглэдэг: «”Оюун сэтгэхүй” нь *санаа* юмуу, *утга учир*, *мөн чанар*, тэр бүү хэл “оюун ухаан” болохын хувьд сэтгэгддэг, ялангуяа бид түүнийг хамтын бүхэллэг зүйлийн мөн чанар гэж сэтгэдэг. Түүний эл бүхэлд оруулах зүй тогтол нь дан хэм хэмжээ заах шинжтэй бөгөөд аль ч талаараа үйл ажиллагаа болохын хувьд тодорхойлогдохгүй, харин үйл ажиллагааны үр дүн ба бүтээгдэхүүнд илрэх журам, төлөвлөгөөг заана. Тэгэхлээр ийм утгаар “оюун сэтгэхүй” нь “ямар нэг юм”-ны амин сүнс байж болох юм. Энд оюун сэтгэхүй “мөн чанар” болон илэрч байгаа учраас “нэгдэл”, тэгэхдээ логикийн “төрөл зүйл”-ийн харилцаанаас ялгаатай, ихэнхдээ ямар нэгэн олонлогийн нэгдэл болж сэтгэгдэх нь гарцаагүй... иймээс энд “ард түмний оюун сэтгэхүй”, “хэлний оюун сэтгэхүй” гэх мэтээр ярьж болох билээ» (Шпет Г. 1989: 531-532)

гэсэн тодорхойлолтыг авбал бидний зорилгод нийцэх юм.

Хэрэв монгол соёл иргэншлийн гал голомт монгол орны тухайд авч үзвэл эл соёл иргэншлийн хөрсөнд цацагдаж, төлжин ургасан өөрийн санаа нь монгол үндэстний оюун сэтгэхүй байх болно. “Зөвхөн үзэл санаа төдийгүй бас судар бичвэр болон эд өлгийн зүйл оюун сэтгэхүйгээр үүсэж, түүний ахуйг өөртөө хадгалаж авч явдаг байна. Жишээлбэл, “Монголын нууц товчоо” хэмээх алдарт зохионгуй нь манай ард түмний сүнс биш, харин оюун сэтгэхүйн бичвэр баримт, соёмбо тэмдэг бол монголчуудын оюун сэтгэхүйн дархлааны бэлгэдэл, эсгий гэр бол эртний монгол оюун сэтгэхүйн уламжлалыг эдүгээтэй холбож өгөх хэлхээ холбоо, түүний орон сав болж байдаг гэж үзэх гүн гүнзгий үндэслэл бий” (Ган-Өлзий Ч. 2007: 43). Тэгэхлээр, үндэстний хэл, шашин, урлаг, утга зохиол, зан суртахуун ба эрх зүй, төрт ёс, аж ахуйн байгуулалын түүхэн үзэгдлүүдийг үндэстний оюун сэтгэхүйн дотоод утгаас үүдэн ойлгох тайлбарлах боломжтой.

Эдүгээ соёмбо нь монгол төрийн сүлд тэмдэг бөгөөд төрийн сүлд болон төрийн далбаа нь дээр байршиж байна. Монгол улсын үндсэн хуулийн 12-р зүйлийн: “3.Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугираг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбо, хослуулан дүрслэсэн байна...”, мөн “5. Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан

дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбыг байрлуулна”

(<https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>) гэж заажээ.

Энэ нь хуулийн заалт хэдий боловч “хөх дэвсгэр”, “мөнх тэнгэр” гэх мэт үг хэллэгийн зах зухаас нь мөшгин үзэхэд л соёмбо нь монголын төрт ёсны түүхэн уламжлалтай нь мэдэгдэнэ. Эртнээс монгол нутагт оршин тогтнож ирсэн төрт улсуудын ёс уламжлал тэнгэр шүтлэгтэй нягт холбоотой байснаас соёмбын оройд байрлах гал, нар, сар гурвыг тахин шүтэж ирсэн талаар: “Хүннү нар нэгэн зүйлийн бичиг үсэгтэй байв. Тэд газар дэлхийг нараар, тэнгэрийг сараар төлөөлүүлэн өвгөд дээдсээ болон өөрсдийгөө, хойч үетэйгээ галын дөл шиг бадарч явахыг бэлгэдэж нар, сар, галын дөл гурвыг МЭӨ III зууны эхнээс төр улсынхаа сүлд болгосон байна. Үүнийг монголын газар нутаг дээр ээлж дараалан тогтсон уламжлан авч сүлд болгон хэрэглэсээр иржээ. Хожим хойно өндөр гэгээн Занабазар титэм үсэг соёмбыг бүтээхдээ төрт насны уламжлалаа бодож Хүннүгийн сүлд нар, сар, галын дөл гурвыг соёмбынхоо оройд залжээ” (Сүхбаатар Г.1980:56) хэмээн түүхч эрдэмтэд бичсэн байна.

Тэр ч нүүдэлчдийн соёлд хүн байгалийн шүтэлцээний асуудал тэнхлэг болдог нь монголчуудын аман болон бичгийн хэлээр уламжлагдан ирсэн утга зохиолын өв сангаас томруун харагдаж байдаг. Ийм соёлд хүмүүс байгалийн сүр хүчийг онголон шүтэж бишрэхдээ орчлонгийн юмс үзэгдэлтэй нэн ойрын холбоо тогтоосон байх агаад «орчлонгийн хамаг амьтан, түмэн бодис цөм сүнс сахиустай» (Пүрэв О. 1998: 59) хэмээх бөөгийн шашин дэлгэрэн, улмаар түүний үндэслэлүүдийг удирдлага болгосон ертөнцийг үзэл бүхий өвөрмөц маягийн нийгмийн цогцлоож чадсан байдаг. Үүний нэг жишээ нь уулс, усыг албан ёсоор тахиж явдлаар илэрдэг.

Эртний энэхүү ёсыг баримталж Чингис хаан Бурхан Халдун зэрэг уулыг тодорхой хугацаанд тахидаг байсан нь түүнээс хойш ч монголчуудын дунд хадгалагдан үлдсэн. Богд хаант монгол улсын үед тэнгэр газрын амьсгал"-ыг бодолцон, нийцүүлэх нэгэн зүйл «Тайх тахилгах ёслолын хууль» боловсруулж байсан мэдээ бий. Одоо ч төр засгийн тэргүүнүүд оролцсон уул улсын тахилга болж, үүнийг байгаль дэлхийгээ хамгаалахад чиглэгдсэн зүй ёсны үйл ажиллагаа гэж үзэж байна.

Байгаль дэлхийн болон сансрын хүчинтэй аж ахуйн харилцан хамаарал бүхий ийм соёл иргэншилд тэнгэр, газрыг шүтэх бөөгийн шашин нь шүтлэгийн хэлбэрээсээ халин гарч тэнгэр үзэл болтол өргөжиж, нүүдэлчдийн нийгмийн бүх хүрээнээ нөлөөлсөнд үндэслэн «монголчууд...тэнгэр-төр гэсэн өвөрмөц шүтлэгтэй байжээ... Энэ нь чинад оюуны ертөнц дэх болон түүний наана буй бодит ертөнц дэх шүтээнтэй байж иржээ...» (Цанжид А. 2019: 73) гэж хэлж болох юм.

Энд өгүүлж буй чинад оюуны ертөнц (Geist) бол дээд эрэмбийн бодит байдал бөгөөд түүний агуулгыг зөвхөн бэлгэ тэмдгээр дамжуулан илэрхийлэх боломжтой. Ерөөсөө рациональ сэтгэлгээний түвшинд боловсруулсан категориуд чинад оюуны бодит байдлыг илэрхийлж чадах уу? хэмээн сэтгэгчид асууж байснаас чинад оюун нь ертөнцийн бодит юм биш, гагцхүү субьектэд нээгдэгч нэгэн боловч байгаллаг холбоос нэвт шингэсэн сэтгэл хөдлөлийн тогтворгүй талтай бас хамаарахгүй – энэ бол объект ба субьектийн эсрэгцлийг даван гарсан оюун сэтгэхүй ажээ. Иймээс түүний агуулгыг бэлгэдэлээр илэрхийлэхээс бус, болзмол шинжтэй тэмдэг илэрхийлж чадахгүй юм. Бэлгэ тэмдэг (symbol) нь ерийн тэмдгээс ялгаатай нь тохиолдлоор сонгон авах боломжгүй, түүнд жинхэнэ

бодит байдлын ахуй шингэсэнд буй: «Символ (ὁ σύμβολος) бол зууч, тэмдгийн хажуугаар холбоос буйг илтгэнэ. Συμβάλλειν гэдэг нь нэгтгэнэ, ялгангаа холбоно гэсэн үг. Бэлгэ тэмдэг, бэлгэдэл нь хоёр ертөнц, ахуйн хоёр эрэмбэ байхыг шаардана. Хэрэв нэг ертөнц, ахуйн нэг дэг журам байх аваас бэлгэ тэмдэг байх боломжгүй. Бэлгэ тэмдэг нь ертөнцийн утга өөр ертөнцөд хамаарахыг, түүнээс утгын дохио ирж байгааг өгүүлмүй. Энэ нь ахуй гагц манай ертөнцөөр хязгаарлагдаагүйг, бас өөр ертөнц байгааг, тэгэхдээ эл хоёр ертөнцийн холбоос, харилцан нэгдэл боломжтойг тухайлна. Бэлгэ тэмдэг нь хоёр ертөнцийг зааглахын хамт холбоно. Манай эмпирик байдлын ертөнц байгаагаараа утга учиргүй, тэрээр өөрийн утга учрыг өөр ертөнцөөс, чинад оюуны ертөнцөөс түүний бэлгэдэл болохын хувьд олж авдаг. Сав ертөнцийн өөрт нь утга учрыг олгогч амьдралын эх булаг байдаггүй, түүнийг чинад оюуны ертөнцөөс бэлгэдлийн байдлаар л олж авдаг. Логос чинад оюуны ертөнцөд оршиж, сав ертөнцөд гагцхүү тусгагддаг буюу бэлгэдэл болдог» (Бердяев Н. 1994:50) гэж үзнэ.

Тиймээс тэнгэр-төрийн шүтлэгт чинад бодит байдлын янад илэрхийлэл нь тэнгэрт түгэх гэгээн байж болох юм. “Соёмбо” бэлгэт тэмдгийн оройд байрлах эл гурван дүрс нь «эрт дээрээс монгол улсын бэлгэдэл болохын зэрэгцээ цаад агуулгаараа Мөнх Тэнгэрийн сүлд бэлгэдэл юм. Нар сар хоёр нь тэнгэрийн тэмдэг (нар нь өдрийн тэнгэр, сар нь шөнийн тэнгэрийг төлөөлнө), гал нь мөнх бадрахын бэлгэдэл... Тийм учраас түүхийн балар эртнээс үе улиран уламжлагдаж ирсэн уг дүрсийг монголчуудын язгуурын уламжлалт шүтээн болсон Мөнх Тэнгэрийн томьёо – тэмдэг гэж болох бүрэн үндэстэй» (Эрдэмт Ц. 2002:13) билээ.

Монгол нутагт эртнээс нааш оршин тогтносон төрт улсууд “хөх

дэвсгэр” бүхий “наран, саран, гал” гурвыг сүлд болгон дээдэлж ирсэн нь эргэлзээгүй. Ойрын түүхээс мөшгин үзвэл Богд хаант Монгол улсын үеэс л “соёмбо” нь төрийн албан ёсны бэлгэ тэмдэг болж төрийн туг далбаа, сүлд дээр ямар нэгэн байдлаар байршиж иржээ. Тэгэхдээ 1940-45 оны завсарт БНМАУ-ын сүлд тэмдэг нь “дугуй хэлбэртэй...дунд нь хангай, тал, говь нутаг дээр нарны зүг уурга бариад давхиж яваа морьтой ард байх ба дугуйн хөвөөгөөр өвс ногооны дээр хонь, үхэр, тэмээ, ямааны толгойг хоёр талд зурж, дугуйн дээд талыг дан алхан хээгээр хүрээлж, дунд нь таван хошуу тэмдэг” тавьсан харагдана. Туг нь дээр уг сүлд тэмдгийг улаан өнгийн дэвсгэр дээр байрлуулж, хоёр талаар нь “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж бичжээ. Үүний шалтгааныг байцааваас (Х.Чойбалсан) «Улс бүхний сүлд тэмдэг болбоос түүний онцлог байдал, түүний шинж байдлыг үзүүлсэн байх ёстой, манай хуучин сүлд тэмдэг нь эдгээр шаардлагууд дор үл тохирохын дээр буддын шашны зүйлсийг өөртөө багтааснаар үл барам манай улсын шинж байдлыг гэрэлтүүлж үл чадамой» (Амарсанаа Ж., Энхжин Ц. 2014:18) гэсэн байна. Ийнхүү улсын сүлд тэмдэг нэгэн үе өөрчлөгдөн соёмбо үгүй үйлдэгдсэн ч түүнээс хойшхи он жилүүдэд алтан соёмбын дээр таван хошууг нэмж залсан нь монголчуудын оюун санаанд явагдсан “хөхөөс шар, шараас улаан дэвсгэрт” шилжсэн түүхийн ажлыг илтгэж байгаа хэрэг.

Эл эгзэгтэй үе дор их эрдэмтэн Б.Ренчин ухаан сийлэн эдүгээгийн монгол улсын төрийн сүлд - соёмбын бэлгэдэл зүйн тайлалыг хийж гүйцэтгэжээ. Уг тэмдгийн утгыг монголын түүх, зан суртахуун, утга зохиол, ёс уламжлалын үүднээс: «энэхүү Соёнбад наран, саран дээр галыг гурван үзүүртэй дөлөөр дүрсэлсэн нь эртний монголчууд галыг маш эрхэм болгож

хүний уг удам залгамжлахын тэмдэг хэмээн гал голомт гэж хэлэлцдэг байсан бөгөөд уул галын дүрс нь гурван үзүүртэй байдаг нь монгол улсын гал голомтыг өнгөрсөн, эдүгээ, ирээдүй гурван цагт буюу үүрд бадран мандаж байх хэмээсэн утгатай тэмдэг болой. Соёнбын доторх гурвалжин дүрс бол монголын эртний утга зохиол, ёс суртахуунд үзвээс эрт цагт дайсны өөдөөс хэрэглэх жад сумны хэлбэрийг дүрсэлсэн бөгөөд дайсныг дарах хэмээсэн утгатай тэмдэг мөн. Үүнд дээр, дороо хоёр хэсэг байдаг нь монголын хүн бүхэн их, бага, эр, эмгүй цөм нэгэн сэтгэлээр монголын тусгаар тогтнон мандахын, дайсныг хаанаас ч гарч ирснийг даран сөнөөхийн тэмдэг болгосон нь болой» (www.e-nom.mn) хэмээн тайлбарлаж өгчээ.

Бидний хөндөж байгаа асуудлын хэлэлцвэл зохих дараагийн тал нь «буддын шашны зүйлсийг өөртөө багтааснаар үл барам манай улсын шинж байдлыг гэрэлтүүлж үл чадамой» хэмээн үгүйсгэгдэхэд хүрч байсан сэтгэлгээний тэр талбараас харин ч соёмбо тэмдгийн гүн утга гэрэлтэх бус уу? гэсэн асуултад оршино. Энэ тухайтад монгол үндэстний оюун сэтгэхүйн “шар дэвсгэр” дээрх ажил хэргийн учрыг нэхэн ойлгохыг оролдоё.

Ингэхдээ эхэнд монгол сэтгэлгээнээ номын утгыг нээхүйд соёмбо бичгийн үүрэг, дараа нь соёмбын гүн ухааны учир холбогдолын асуудлыг авч үзье.

Урьд монгол оронд бурхны шашин гурвантаа дэлгэрсэн гэдэг. Ингэхдээ сүүлд Наландэрийн уламжлалтай Их хөлгөний шашин эртний Энэтхэгээс Төвдөөр дамжин (XIX зуунд) дэлгэрснээс Монгол орон төв үзлийн хөгжлийн нэгэн төв болж байсан цаг бий. Энэ талаас үзвэл, “Бурханы сургаалыг ойлгохгүйгээр Дорно дахины Энэтхэг болон Хятадын зэрэг аугаа соёлуудыг ойлгох

боломжгүй, тэр тусмаа бурхны шашны үзэл санаа эцсийн үндэс хүртэл нь нэвтэрсэн Түвд, Монголы соёлын талаар яриад ч нэмэргүй” (Торчинов Е.А. 2023: 4) гэж хэлж болно. Нөгөө талаас, эртний энэтхэгийн нэгэнт мөнхөж буй шашныг сэргээх бүтэлгүй ородлого гэх үнэлгээ ч байдгийг дурдах хэрэгтэй. А.Тойнби «...хэрэг дээрээ үүслийн асуудлыг даван гарсан ч өсөлтийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй олон «зогсонги» соёл иргэншлүүд байсан... энэ хоёр жишээн дээр бидэнд нэгэнт танил болсон бусад бөхөж буй соёл иргэншлийн: Энэтхэгийн жайнууд, Цейлон, Бирм, Сиам болон Комбоже дэх бага хөлгөнтөн, их хөлгөний Түвд болон Монголын буддист-ламаистууд (тэд цөм энэтхэгийн соёл иргэншлийн хөшсөн фрагментууд)-ын янз бүрийн хөшсөн фрагментуудыг нэмж болох юм» (Тойнби А. 2009:7) гэж бичжээ. Гэтэл монголд бурхны шашин дэлгэрсэн нь бусад газрынхаас ялгарах юмгүй хуулбар байсангүй, харин ч буддизм бүх талаараа сэлбэгдэн хөгжсөн (aufhebung) гэж үзэх үндэстэй.

Үүнд хоёр зүйлийг үндэслэл болгоё.

Нэгдүгээрт, монголд их хөлгөний шашин гүнзгий нэвтэрч, монгол сэтгэгчид төв үзлийн философийн асуудлаар нарийн судалгаа хийж байсан нь санамсаргүй хэрэг биш бөгөөд нөхцөл бүрэлдээгүй цагт ямар ч үзэл онол амьдралын хөрсөнд хэрэгждэггүйг санах хэрэгтэй. Өргөн уудам нутагт аж төрж ирсэн монгол хүний “сэтгэхүй уужим бөгөөд гүнзгий, сэтгэл нь ариун бөгөөд талбиун, зан араншин нь төвшин бөгөөд шударга” тул юмсын ахуй ёсыг мэдэхийг эрмэлзэж, ер авах гээхийн ухааныг баримталж иржээ (энэ амьдрах ухааны туршлагыг монгол хүний билиг ухааны ерөнхий удирдамж болж ирсэн эртний мэргэн ухааны өв “Оюун түхүүр шаштир”-аас үзэж болно). Аливаа туйлширсан хязгаарыг хаадаг Мадхьямака гүн ухаан монгол хөрснөө

шимлэн хөгжсөн явдал монгол үндэстний оюун сэтгэхүйн энэ (мухар үзэл, буруу бодлыг амьдрах ухааны туршлагаар хоридог) язгуур хэв шинжтэй нийцэж байсанд оршино.

Хоёрдугаарт, монгол орон буддын соёл иргэншлийн бүсэд багтах болсонд түүний нэгэн “хөгшсөн фрагмент” төдий болсонгүй. Харин ч монгол оюун сэтгэхүйн бүтээлч хүчин чадал улам өссөн нэмэгдсэн юм. Буддын шашны зүйлсийг өөрийн ахуй соёлд нийцүүлэн бүтээлчээр хөгжүүлж, эрин үеийн давтагдашгүй содон бүтээлүүдийг урласан байдаг. Тухайлбал, Энэтхэг-Төвдийн бурхдыг Өндөр гэгээн Занабазар хэрхэн монгол дүр төрхтэй урласан талаар нэрт эрдэмтэн Л.Хүрэлбаатар: «энэ бол бурхдын лагшин, зарлиг, талаалал, үйлсийн эрдмийг 32 тэмдэг, 80 найраг, 60 эгшиг, 64 ид заль, 12 зохионгуй, хүслийн таван эрдэм, хоёр үнэний хувиар дүрслэн илэрхийлж, тогтоож шинжилж ирсэн бурханы шашины гүн ухааны урлагийн тогтсон таалалын хувь хэмжээ, хэлбэр дүрс, өнгө зохилцлыг хатуу чанга барих мөртлөө эвдэж, чөлөөт олон боломжийг нээх атлаа, тогтсон хэв загварт нь эргэн хариулж, хэсэг бүхэл, ерөнхий тусгайн хам нэгдэлд нь, үлгэрлэх дүрслэхийн олон шалтгаанд нь чөлөөтэй шилжүүлж “идээшүүлж” чадсан... » [Л.Хүрэлбаатар, 2002, 36-37] гэжээ. Энэ бол амьдрал дээрх бодит өсөлт, дэвшилт билээ. Энэ хувьдаа “ардын буддизм” зэрэг хэт номчирхсон (өөрөөр хэлбэл, бодит байдалд нийцээгүй) ойлголтод шүүмжлэлтэй хандмаар санагддаг.

Бүх шашны уг эхийн газар ижил боловч харилцан адилгүй нөхцөлд оршдог. Хэдийгээр дүр төрх ижил байвч тэдгээр нь давтагдашгүй агуулгаар нөхцөлдсөн байх учраас нэгэн хэв загварт баригдах боломжгүй. Бодит байдал дээрх ийм өсөлт дэвшилтийг хөгжил гэж ойлгохоос өөр аргагүй.

Бурхны шашин монгол соёлын хөрсөнд идээшснээр монгол үндэстний оюун сэтгэхүйн бүтээлч хүчин нэмэгдсэн юм. XVI-XVII зууны зааг үеэс эхлэн бурхны шашин монголын нийгмийн оюун санааны амьдралын бүх хүрээг нэвтэрч “үндэсний ухамсрын сэргэлт” хэлбэрээр илрэх болсныг монголын соёлын сэргэн мандалтын үе гэж эрдэмтэд дүгнэдэг (ШУА-ФСЭХ. 2001). Энэ үест үндэстний хэмжээний оюун санааны удирдагчид төрөн гарахын хамт шашины сургууль дацангууд байгуулагдсан байна. Мөн бурханы их хөлгөн судруудын цомирлог Ганжуур, мэргэн бандит нарын тайлал номлолыг нэгэн зүг хураасан Данжуур зэргийг орчуулснаар буддын гүн ухааны ойлголт ухагдахууны тогтолцоог монгол сэтгэлгээнээ буулгах хэд зуун дамнасан ажил сая хийгдэж дууссан билээ.

Оюун сэтгэхүй шууд хүртээлгүй, гагцхүү илрэлүүдээрээ (хэл, соёл, шашин гэх мэт) дамжин нээгддэг (түүгээр бодгаль шинжийг олдог) талаар бид дээр дурдсан. «Үндэстний хэл бол түүний оюун сэтгэхүй, үндэстний оюун сэтгэхүй бол түүний хэл мөн, үүнээс өөр адилсах зүйлсийг төсөөлөхөд ч бэрх» (Гумбольдт В. 2000: 68) гэж үзвэл буддын гүн ухааны ухагдахууны тогтолцоог монгол хэлэнд буулгасан төдийгүй дээдийн номыг гийгүүлэх “Соёмбо” хэмээх эрхэм бичиг үгийг шинээр зохиосон явдал монгол оюун сэтгэхүйн бүтээлч хүчин чадлын нэгэн илэрхийлэл болох бус уу. Энэ бол бас л, өмнөх бичиг үсгүүдийн (дөрвөлжин үсэг, али гали үсэг тод үсгийн) шилдэг ололт бүхнийг багтааж олон зууны туршид хийгдсэн үндэстний оюун сэтгэхүйн ажил хэрэг гэхэд хилсдэхгүй.

Энэтхэг, Төвд хэл дээрх дээдийн мэргэн ухааныг монгол хэлнээ оршоохуйд, нэн тэргүүнээ судрын үгийг бичих дуудах явцад “эндүүрэл эвдрэл гарч болох бэрхшээл хүчирдэлтэй тул хялбар дөхмийг болгоон бодож тийм

нэгэн үсгийг зохиожээ”(Хүрэлбаатар Л. 2001:) [бас улс төрийн шалтгаан байсан гэж үздэг]. Соёмбо бичиг нь 90 үсэгтэй, голдуу зүүнээс баруун тийш бичдэг бөгөөд үндсэн гийгүүлэгч махбодын хэлбэр дүрс хувирдаггүй, эгшиг авиаг тэмдэглэдэг туслах тэмдгийг нэмж бичдэг бөгөөд үеэр үг бүтээдэг тул үет бичигт тооцогддог байна. Энэ бичиг үсэг нь номт гурван улсын номын хэлийг үсэг солилгүйгээр хувь сацуу тэмдэглэн буулган чадаж байгаад давуу тал оршино. Үүнийг судласан эрдэмтэд «...энэ бол тухайн үедээ утга зохиолын хэлний авиалбарын тогтолцоог дорно дахины хэл шинжлэлийн сонгодог уламжлал, Энэтхэгийн хэл шинжлэлийн арга билгийн зарчим, авиа үсгийн дайсагнах садагнах ёс, таван махбодын онолд тулгуурлан мөнхдөх тасархайтахын хоёр хэтийдэлд эс унан, хамгийн зөв ухаарч, хэдэн зууны дараах хэл шинжлэлийн төвшинд хүртэл хүргэж шийдсэн шинжлэх ухааны үнэн...» (Хүрэлбаатар Л. 1996:13) байсантай санал нийлдэг. Өндөр гэгээн соёмбо үсгээр Ганжуурыг шинэчлэн бүтээх таалалтай байсан боловч удалгүй эхэлсэн цаг төрийн хямралаас шалтгаалж хараахан завдаагүй ажээ.

Харин бидний судлагдахуун соёмбо тэмдэг нь уг хэлзүйн харилцаанд бол, гар бичмэл, судар номын эхэнд шинэ хуудас юмуу догол эхэлсний тэмдэг болдогоороо нэгэн зүйлийн бярга юм. Түүнээ эрт, дундад үеийн ном судруудын дотор дайралддаг наран-саран-дусал-гурвалжин-ташуу хэлбэрт эгчимүүд бүгд багтан орсон нь ажиглагдана. Соёмбо бичгийн охь хураангуй гэдэг утгаар “э вам”(ཨ་ཨ) ч гэж нэрлэдэг байна.

Ийнхүү соёмбо тэмдэг нь юмсын эхлэлийг заахын хамт эртний самгарьд хэлний дүрс тэмдэгтэй байгаа нь дорнын гүн ухааны холбогдолтойг илтгэнэ. Буддын гүн ухааны судруудын эхний мөрүүд энэ үгээр: *Evam mayā śrūtam* (“ийн хэмээн миний сонссон нэгэн цагт”)

гэж эхэлсэн байдгаас үзвэл нэгэн зүйлийн логик мөрдөлгөөний үүрэгтэй бөгөөд тухайн судрын дамжлага үнэн бодитой, тэр нэгэн шарвага өөрийн биеэр сонссоны баталгааг өгүүлэх ажээ.

Соёмбо үсэг нь самгарьд бичгийн хэлний тигээр бүтээгдсэн. Тус хэлний “э бам” хэмээхийн “э”-г урвуу харсан гурвалжингаар, “вам”-ыг босоо зурдасаар төлөөлүүлэн (дээрээ дусал бүхий) соёмбо үсгийн үндсэн махабодыг бүтээжээ. Энэ үсгийн тухайтад Жанжаа Ролбийдорж бээр “эвам үсгийн дүрс хэрхэн бүтээх заавар номлол байх боловч урьдын Энэтхэг, Төвөдийн мэргэд яг тэр ном дагуу бүрэн гүйцэд, тодорхой бүтээсэн нь үгүй. Харин энэ үе шат мутарлагын зураг нь номтой бүрэн зохилдож, маш уран тансаг болсноороо онцгой гайхамшигтай бүтээл болжээ” гэсэн байна.

Шат мутарлагын зураг нь “ном”-той хэрхэн зохицов хэмээн мэргэд дээдсийн туурвилаас мөшгин үзвэл судар, тарнийн үүднээс хийсэн олон тайлбар байх. Үүнээс бидний хэл хүрэлцэх хэмжээгээр хоёр зүйлийн ерөнхийг дурдсу.

Эвамын тамганд бурхны айлдсан 84000 мянган номын цогсын оршоон бэлгэдсэнээс лагшин, зарлиг, тааллын үүднээс тайлбарладаг уламжлалтай. Эл “найман түмэн дөрвөн мянган номын цогцсын шүтээн хийгээд үндсэн нь энэ хоёр үсэг бөгөөд үлгэрлэвээс эцэг эх бээр хөвгүүн үүсгэхүй лүгээ адил” гэж үздэг байна. Тэгэхлээр “Э үсэг нь эх адил болоод үүгээр билгийн үсэг 16 эгшгийг... Ва үсэг нь эцэг лүгээ адил бөгөөд аргын 34 гийгүүлэгчийг...дуслаар эгшиг хийгээд гийгүүлэгч үсгүүдийг харилцан тэгш барилдсан...”-ыг бэлгэдэмүй (энэ номт гурван улсын хэлнээ ижилхэн). Эцэг эх хоёрын барилдлага лугаа эгшиг гийгүүлэгч тэгш барилдснаас нэр хийгээд түүнд шүтсэн үгс, цаашлаад үгсийн чуулган, бадаг шүлэг, эцэст нь номын цогц бүтэх ажээ.

Ер ном хэмээгч нь өвөрчлөнгөөр бүтээгүй, өөрийн нэрийдэх суурьт харгалзан гарах учраас түүний тэр ямагт чанарыг үзүүлэхийн тухайдтад А тэргүүтэн эгшиг дохиог зарлиглаж хэл лүгээ зохилдуулан үсгийн үрийн элдэв байдал бий болсон гэж Бурхны сургаалд айлдсан байдаг. Тухайлбал: “Жамбалцанжод”-аас:

«Энэ мэт Ялж төгс нөгчсөн
Туулсан бурхан А үгсээс болсон
А хэмээмээс хамаг үсгүүдийн дээд
Их утгат егүүтгэл үгүй дээд болой
Их амь болоод төрөх үгүй
Аялгуугаар өгүүлэхийг тархаасан
Хамаг үсгийн шалтгаадын дээд
Хамаг үсгийг сайтар гийгүүлэюү...»
 (“Цогт цагийн хүрдэн” соёлын төв. 2015: 46 - 47) хэмээн зарлиглажээ.

Тэгэхлээр, аливаа мэдэгдэхүүний, тухайлбал А дүрс үсгийн үнэмлэхүй утгын чанарыг хэлэшгүй (хоосон) бөгөөд гагцхүү томьёолох мэдлийн эрхэнд тэр мэт юмс урган гардаг байна. Жишээлбэл: Төвөд хэлний их А үсэг нь эшигт тооцогддоггүй ч бүх гийгүүлэгчийг амилуулдаг “тэг эгшиг”-гэмээр үүрэгтэй байдаг нь сонихолтой үзэгдэл юм. Э вам нь хэлний талаар ийм бөгөөд бусад семантик талбарт ч ургуулан найруулж болох байна: Төрийн улсын бэлгэт тэмдэгт “соёмбо” ямар утга илэрхийлэхийг дээр дурьдсан билээ (арга билиг, судар тарни хосолсон шашин төрийн гүн утгатай “э вам” бэлгэдэл нь Богд хаант монгол улсын төрийн далбаан дээр соёмбо үсгээр бичээстэй байдаг)

Харин нууц тарнийн ёсноо эцэг эх хоёр эвлэлцсэн дүрийг үзүүлсэн нь хоёр үгүй (non-dual unity)-тэй холбогдох бололтой. «Хоёр үгүй дандарын утгыг болгоосны үзэгдэлд ургасан соёмбо-зояади хэмээх зураг дүрсээр увдислан зохиосон» (Өндөр Гэгээн Занабазар. 2016: 48) гэсэн байна. Энэ талын тайлбар сэлт хомс үзэгдэх бөгөөд мэргэд дээдэс

“нууцын орон мөн тул нийтэд дэлгэн алдаршуулаагүй”, “нууц нэгэн буйг аман гэгээнээс мэд” зэргээр айлджээ. Юутай ч судал, хий, дуслын тогтторыг арилгах гэгээрлийн мөрийн зэрэг, - хүний дотоод эрчим, биеийн энергийн төвүүдтэй холбогдох талаас нь үзвэл соёмбо тэмдэг нь бясалгалын объект ч болох боломжтой юм.

ТАЛАРХАЛ

Монгол-Оросын хамтарсан «Олон төвт ертөнц дэх монголчуудын адилсал» (ЭЗХЯ/126-03) сэдэвт суурь судалгааны төслийн дэмжлэгтэйгээр бичигдсэн болно.

ДҮГНЭЛТ

“Соёмбо” бэлгэт тэмдэг нь байгаль эхийг шүтэн бий болсон Монгол соёл иргэншлийн гүнээс улбаатай бөгөөд монгол үндэстний оюун сэтгэхүйн чинад утгыг тусгах гайхамшигт феномэн болох учраас түүний (монгол соёл иргэншлийн) арга билгийн зохилцлыг тусган илэрхийлж чадах юм. Тэр хувьд монгол сэтгэлгээний дархлаа, төрийн эрхэм сүлд, үндэстний ижилсэл ондоошлын гол бэлгэ тэмдэг тэмдэг хэвээр байна. Соёмбо тэмдгийн хувирал өөрчлөлтийн түүх нь өөрөө монгол оюун сэтгэхүйд явагдсан түүхийн ажил хэргийн учрыг тод илтгэн байх авай. Түүний агуулгыг философи, хэл зүй, шашин, түүх, бэлгэдэл зүйн талаас нь цогцоор ойлгох шаардлагатай.

Ашигласан материал

- Монгол хэлний их тайлбар толь.
mongoltoli.mn
- Монгол улсын үндсэн хууль.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Гадамер Г. 1988. Истина и метод: основы философской герменевтики. М.: Прогресс. 704 с.
- Шпенглер О. 2023. Закат Европы: Том 1. Очерки морфологии мировой истории: Азбука-Аттикус. 698 с.
- Цанжид А. 2005. Монгол соёл иргэншил. УБ.: Мөнхийн үсэг. 193 х.

- Цанжид А. 2019. Монголын төрт ёс. УБ.: Соёмбо принтинг. 272 х.
- Ган-Өлзий Ч. 2022. Чингис хааны үеийн монгол философи. УБ.: Соёмбо принтинг. 160 х.
- Гегель Г. 2014. Лекции по философии духа. Берлин 1827/1828. М.: Издательский дом «Дело». 304 с.
- Шпет Г. 1989. Введение в этническую психологию// Г.Шпет. Сочинения. М.: Издательство правда. 601 с.
- Ган-Өлзий Ч. 2007. Эдүгээгийн философид эхлэн орохуй. УБ.: Бэмби сан. 252 х.
- Сүхбаатар Г. 1980. Монголчуудын эртний өвөг. УБ.: ШУАХ.
- Бердяев Н.А. 1994. Философия свободного духа. М.: “Республика”. 480 с.
- Эрдэмт Ц. 2002. Төрийн тухайт монгол онол: түүх, философи, хуулийн эши. УБ.: CHOIJARGAL PUBLISHERS. 315 х.
- Амарсанаа Ж., Энхжин Ц. 2014. Монгол улсын төрийн бэлгэ тэмдэг. УБ.: “Мэргэн их Монгол” хэвлэлийн газар. 262 х.
- Пүрэв О. 1998. Монгол бөөгийн шашин. УБ. Л.Дашням. Язгуураа танихуйд өчүүхэн дусал. УБ., 2020.
- ШУА-ФСЭХ. 2001. Монголын философийн түүх / XVII-XIX ЗУУН /. III дэвтэр. УБ.: “Бэмби Сан”. 331 х.
- Ренчин Б. Соёнба тэмдэг бол монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын алдарт сайхан билэг тэмдэг мөн. “Утга зохиол” 1991. № 22 // Монголын за - андгаар буй заа – V. <https://www.e-nom.mn/book?bid=MTQ4Mg==enonMTQ4Mg==>
- Торчинов Е.А. 2023. Введение в буддизм. М.: АСТ. 512 с.
- «Исследование истории: Цивилизации во времени и пространстве»:
- Тойнби А. 2009. Исследование истории: Цивилизации во времени и пространстве. М.; АСТ. 863, [1] с.
- Гумбольдт В. 2000. Избранные труды по языкознанию. М.: “Прогресс”. 400 с.
- Хүрэлбаатар Л. 1996. Огторгуйн цагаан гарьд. УБ.: Өнгөт хэвлэлийн газар. 326 х.
- Хүрэлбаатар Л. 2001. Анхдугаарбогд// “Монголын 100 хаан, найман богд”. 108 боть цуврал. УБ., 325 х.
- Шамбал нийгэмлэг. 2005. Соёмбын нууц ба синергетик. УБ.: 650 х.

“Цогт цагийн хүрдэн” соёлын төв. 2015.
Номын гэгээ 2: Жамбалцанжод.УБ.:156 х.
Өндөр гэгээн Занабаяр. 2016. Адистэдийн
дээдийг хайрлагч эх (орчуулга, тайлбар).
ШУА-ийн ФХ. Төвд хэлнээс орчуулж,
тайлбар хийсэн: Р.Алтансүх, Б.Ариунзул.
УБ.,
Бусад эх сурвалжууд:
Шагдарсүрэн Ц. 2001. Монголчуудын бичиг
үсгийн товчоон (үгэг зүйн судалгаа).
УБ.:URLAKH ERDEM. 300 х.

Кара Дорж. 1972. Книги монгольских
кочевников (сем веков монгольской
письменности). М.:«Наука». с 228.
Загасбалдан Батжаргал (2013).
Национально-культурная идентичность
как современная проблема (на примера
Монголии): Диссертационная работа на
соискание учёной степени культурологии
(Ph.D).